



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/99

Цагаан-Уул сум

**Газар эзэмшүүлэх эрх олгох дуудлага
худалдааны тов зарлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоол, 2024 оны 136 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, Цагаан-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Цагаан-Уул сумын 6 дугаар баг “Магнай трейд” шатахуун түгээх станцын хажууд байршилтай төлөвлөлтийн 3885939 дугаарын нэгж талбартай, 1206м² талбайтай, 964800 төгрөгийн ахны үнэтэй, шатах, тослох материал түгээгүүр, агуулахын зориулалттай газрыг 25 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэх эрх олгох дуудлага худалдааг 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 09:00-15:00 цаг хүртэл цахим хэлбэр (www.mle.mn) буюу газрын цахим биржээр зохион байгуулсугай.

2. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг явуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу цахимаар зохион байгуулж ажиллахыг сумын Газрын даамал (А.Энхбаатар)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-түүрэг болгосугай.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ

/Zahiramj 2024/